



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар A/582

Булган сум

Зарим сумдад спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундааг худалдан борлуулахыг түр хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Юнескогийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвд Монгол улсаа төлөөлөн бүртгэгдсэн Хөхүүрийн айрагны соёлын Монголын хамгийн том баяр "АЙРАГ ФЕСТИВАЛЬ- 2023" 14 дэх удаагийн наадам Булган аймагт зохион байгуулагдахтай холбогдуулан Бугат, Орхон, Хутаг-Өндөр, Сайхан сумдад 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 13-ны өдрийг дуустал спиртийн өндөр агууламжтай буюу 18 хувиас дээш этилийн спирт агуулсан согтууруулах ундааг худалдан борлуулахыг түр хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Бугат, Орхон, Хутаг-Өндөр, Сайхан сумын Засаг дарга нарт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Г.Алтанцэцэг)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

6323010477